**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ГСА-2021/9/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойр хот<br><br>2021 он | Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 7054-3156<br>Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер:<br>Г.Наранбаяр<br>Утас: 7054-3179<br>Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn<br>Аудитор: М.Ундармаа<br>Утас: 7054-3179<br>Цахим хаяг: Undarmaam@audit.gov.mn: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3. Аудитын тайлан ..... 13
3.1. Ерөнхий зүйл ..... 13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 13
3.4. Материаллаг байдал ..... 14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 15
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
3.9. Аудитын илрүүлэлт ..... 17
Залруулсан алдаа ..... 17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 17
Аудитын зөвлөмж ..... 18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 18
4. Менежментийн захидал ..... 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 20

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,544,760.00** | **100,432,544.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 691,100.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 691,100.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 691,100.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 691,100.00 |
| **33** | **Авлага** | - | 13,120,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 13,120,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 53,544,760.00 | 86,621,444.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 217,110.00 | 407,300.00 |
| 35130 | Эм боох материал | 217,110.00 | 407,300.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 53,327,650.00 | 86,214,144.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,158,950.00 | 1,537,050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 51,962,100.00 | 84,425,294.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 206,600.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 251,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,303,815,010.09** | **2,359,885,739.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,303,815,010.09 | 2,359,885,739.09 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,269,281,879.97 | 1,325,263,739.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,291,330,713.23 | 1,324,299,103.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (45,172,214.52) | (90,344,429.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 57,000,000.00 | 45,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (57,000,000.00) | (2,800,000.02) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,719,240.15 | 29,118,981.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (35,996,821.67) | (8,246,117.81) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,686,140.00 | 11,331,970.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,472,950.76) | (7,281,716.60) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 65,329,100.00 | 33,896,570.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (51,141,326.46) | (9,710,621.82) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,034,533,130.12 | 1,034,622,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,250,000.00 | 525,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,038,869.88) | (225,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,034,322,000.00 | 1,034,322,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,357,359,770.09** | **2,460,318,283.09** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,357,359,770.09** | **2,460,318,283.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,357,359,770.09 | 2,460,318,283.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,475,624,319.00 | 2,475,624,319.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,475,624,319.00 | 2,475,624,319.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (434,854,810.49) | (358,822,293.49) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (434,854,810.49) | (434,854,810.49) |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 76,032,517.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 316,590,261.58 | 343,516,257.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,357,359,770.09** | **2,460,318,283.09** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **419,142,955.00** | **531,410,733.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **28,276,050.00** | **117,786,433.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 28,276,050.00 | 117,786,433.00 |
| 120003 | Торгуулийн орлого | - | 314,043.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 28,276,050.00 | 117,472,390.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28,276,050.00 | 18,529,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 931,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 98,012,290.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **390,866,905.00** | **413,624,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 75,628,705.00 | 56,918,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,544,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,626,005.00 | 56,918,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 458,700.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 315,238,200.00 | 356,706,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 315,238,200.00 | 356,706,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **463,283,221.08** | **455,378,216.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **463,283,221.08** | **455,378,216.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 461,260,670.08 | 438,745,944.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 163,276,725.00 | 191,227,044.00 |
| 210101 | Үндсэн цалин | 163,276,725.00 | 135,775,787.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 41,593,057.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 13,858,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,966,729.00 | 23,602,982.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,966,729.00 | 16,524,599.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 1,944,065.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 1,538,454.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 326,897.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 3,268,967.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 110,819,250.00 | 97,341,257.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,452,415.00 | 7,634,972.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,044,832.00 | 80,453,825.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,322,003.00 | 9,252,460.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,220,020.00 | 14,918,224.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,120,350.00 | 727,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,405,500.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,165,880.00 | 1,457,810.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 300,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 7,165,850.00 | 9,080,750.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,122,440.00 | 2,352,564.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 85,010.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 85,010.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 2,185,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 2,185,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,693,700.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,693,700.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,798,000.00 | 3,819,780.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 160,000.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,000.00 | 219,420.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 112,500.00 | 112,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,035,000.00 | 1,033,860.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 105,500.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 146,401,236.08 | 105,651,657.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,782,100.00 | 52,548,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,619,136.08 | 53,103,657.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,022,551.00 | 16,632,271.22 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 1,988,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,988,040.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 22,551.00 | 14,644,231.22 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,551.00 | 14,644,231.22 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(44,140,266.08)** | **76,032,517.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(44,140,266.08)** | **76,032,517.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **419,142,955.00** | **433,084,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,093,050.00** | **19,460,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,093,050.00 | 19,460,100.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 22,093,050.00 | 19,460,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,093,050.00 | 18,529,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 931,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **397,049,905.00** | **413,624,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 81,811,705.00 | 56,918,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,544,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,626,005.00 | 56,918,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,641,700.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 315,238,200.00 | 356,706,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 315,238,200.00 | 356,706,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **419,142,955.00** | **432,393,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **419,142,955.00** | **432,393,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **417,120,404.00** | **402,641,028.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 163,177,757.00 | 190,913,001.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,720,797.00 | 136,208,486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 8,962,960.00 | 46,062,515.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,494,000.00 | 8,642,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,065,697.00 | 23,602,982.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,065,697.00 | 16,632,296.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 1,518,533.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 1,520,532.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 357,421.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 3,574,197.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 110,819,250.00 | 97,341,257.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,452,415.00 | 7,634,972.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,044,832.00 | 80,453,825.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,322,003.00 | 9,252,460.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,253,500.00 | 8,756,068.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,100,100.00 | 1,098,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,323,500.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,165,880.00 | 1,457,810.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,424,020.00 | 4,899,558.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,620,000.00 | 8,189,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,700,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 300,000.00 | 1,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,620,000.00 | 6,889,940.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,693,700.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,693,700.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,798,000.00 | 3,819,780.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 160,000.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,000.00 | 219,420.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 112,500.00 | 112,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,035,000.00 | 1,033,860.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 105,500.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 102,692,500.00 | 70,018,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,692,500.00 | 70,018,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,022,551.00** | **29,752,271.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 15,108,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 15,108,040.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 22,551.00 | 14,644,231.22 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,551.00 | 14,644,231.22 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **691,100.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 691,100.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 691,100.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,475,624,319.00 | 316,590,261.58 | -390,714,544.41 | 2,401,500,036.17 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,475,624,319.00** | **316,590,261.58** | **-390,714,544.41** | 2,401,500,036.17 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -44,140,266.08 | -44,140,266.08 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,475,624,319.00** | **316,590,261.58** | **-434,854,810.49** | 2,357,359,770.09 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,475,624,319.00** | **316,590,261.58** | **-434,854,810.49** | 2,357,359,770.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,475,624,319.00** | **316,590,261.58** | **-434,854,810.49** | 2,357,359,770.09 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 26,925,996.00 | 0.00 | 26,925,996.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 76,032,517.00 | 76,032,517.00 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,475,624,319.00** | **343,516,257.58** | **-358,822,293.49** | 2,460,318,283.09 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 337,238,200.00 | 337,224,199.00 | 378,706,300.00 | 360,533,068.78 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 337,238,200.00 | 337,224,199.00 | 378,706,300.00 | 360,533,068.78 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 335,238,200.00 | 335,224,199.00 | 376,706,300.00 | 358,545,028.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 162,652,000.00 | 162,651,797.00 | 197,083,500.00 | 190,913,001.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,721,000.00 | 140,720,797.00 | 157,876,000.00 | 136,208,486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 8,437,000.00 | 8,437,000.00 | 33,883,500.00 | 46,062,515.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,494,000.00 | 13,494,000.00 | 5,324,000.00 | 8,642,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,000,000.00 | 19,999,952.00 | 24,635,400.00 | 23,602,982.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,000,000.00 | 19,999,952.00 | 16,991,000.00 | 16,632,296.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | - | 1,911,100.00 | 1,518,533.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | - | 1,528,800.00 | 1,520,532.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | - | 382,300.00 | 357,421.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | - | 3,822,200.00 | 3,574,197.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,826,200.00 | 106,819,250.00 | 107,211,400.00 | 97,341,257.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,451,800.00 | 11,452,415.00 | 12,000,000.00 | 7,634,972.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 83,071,400.00 | 83,044,832.00 | 81,711,400.00 | 80,453,825.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,303,000.00 | 12,322,003.00 | 13,500,000.00 | 9,252,460.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,930,000.00 | 7,930,000.00 | 8,840,000.00 | 8,756,068.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 1,100,100.00 | 1,100,000.00 | 1,098,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,390,000.00 | 1,165,880.00 | 1,540,000.00 | 1,457,810.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 | 300,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,500,000.00 | 4,424,020.00 | 4,900,000.00 | 4,899,558.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,120,000.00 | 5,120,000.00 | 8,200,000.00 | 8,189,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 300,000.00 | 300,000.00 | 1,300,000.00 | 1,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,620,000.00 | 3,620,000.00 | 6,900,000.00 | 6,889,940.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,700,000.00 | 1,693,700.00 | - | - |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,700,000.00 | 1,693,700.00 | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,010,000.00 | 2,009,500.00 | 2,736,000.00 | 1,761,780.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 800,000.00 | 972,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,000.00 | 215,000.00 | 220,000.00 | 219,420.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 113,000.00 | 112,500.00 | 113,000.00 | 112,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 132,000.00 | 330,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 684,000.00 | 684,000.00 | 1,035,000.00 | 1,033,860.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,000,000.00 | 29,000,000.00 | 28,000,000.00 | 27,980,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,000,000.00 | 29,000,000.00 | 28,000,000.00 | 27,980,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 1,988,040.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 1,988,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 1,988,040.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 315,238,200.00 | 315,215,649.00 | 356,706,300.00 | 342,062,068.78 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 315,238,200.00 | 315,215,649.00 | 356,706,300.00 | 342,062,068.78 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 315,238,200.00 | 315,215,649.00 | 356,706,300.00 | 342,062,068.78 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.00 | 17.00 | 18.00 | 17.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | - | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 9.00 | 10.00 | 9.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | 7.00 | 7.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 1.00 | | 1.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **18.00** | **17.00** | **18.00** | **17.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 3.00 | 2.00 | 3.00 | 2.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 14.00 | 15.00 | 14.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | 1.00 | | 1.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **73,852,500.00** | **43,798,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **73,852,500.00** | **43,798,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 73,852,500.00 | 43,798,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 160,000.00 | 2,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 160,000.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 73,692,500.00 | 41,798,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,692,500.00 | 41,798,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 75,170,005.00 | 56,918,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 75,170,005.00 | 56,918,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,170,005.00 | 56,918,000.00 |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2021.02.23 № 19

танай ______________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Б.БУЯНТОГТОХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилт, 81 арга хэмжээ төлөвлөснөөс 21 зорилт, 77 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан ба аймгийн ТЕЗ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92.0%-тай дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Буянтогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд орлогын төлөвлөгөө болон цахим татварын системийн талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 15–ны хооронд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ундармаа хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

2020 онд Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар” нь “Эрүүл чийрэг бие бялдартай иргэд хамт олныг төлөвшүүлж, биеийн тамир, спортыг нийтийн хүртээл болгон сонгон хөгжүүлж буй спортын төрлүүдээр спортын өндөр ур чадвар, цол зэрэгтэй тамирчдыг бэлтгэх” эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

- Иргэн болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг дэмжин ажиллах, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгож сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар” нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-т дээд шатны байгууллага болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3-р улирлын болон жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 295,389.2 мянган төгрөгөөс тооцон 2,953.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 455,378.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4,553.7 мянган төгрөгөөр дахин тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,737.4 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 691.10 | 691.10 |
| Авлага | | 13,120.00 | 13,120.00 |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 53,544.76 | 86,621.44 | 33,076.68 |
| Үндсэн хөрөнгө | 2,303,815.01 | 2,359,885.74 | 56,070.73 |
| **Нийт хөрөнгө** | **2,357,359.77** | **2,460,318.28** | **102,958.51** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,357,359.77 | 2,460,318.28 | 102,958.51 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,357,359.77** | **2,460,318.28** | **102,958.51** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 691.1 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд Төрийн сангийн нэгдсэн данснаас ахмадын сангийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг байгууллага тус бүрд харилцах данс нээж бүртгүүлснээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 13,120.0 мянган төгрөгөөр өссөн нь цахим фитнес төслийн хүрээнд зарцуулах санхүүжилтийг цаг хугацаанаас шалтгаалан он дамжуулан зарцуулахтай холбоотой орон нутгийн дансанд төвлөрүүлэн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86,621.4 мянган төгрөг болж 33,076.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 30,465.2 мянган төгрөгийн бараа материалыг бэлтгэж, аймгийн ИТХ-ын 2020.06.30-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 30 ширхэг бөмбөг 6,000.0 мянга, 2020.12.28-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор усан спорт сургалтын төвийн бассейны засварын ажилд шаардлагатай 9,763.9 мянга, нийт 15,763.9 мянган төгрөгийн бараа материалыг ОНХС-гаас санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан болович ашиглалтгүй бараа материал илрээгүй бөгөөд оны эцэст бараа материалын нөөц үүсгэх зорилгоор худалдан авалт хийгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,501,637.2 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын 2020.12.28-ны өдрийн 79-р тогтоолоор усан спортын төвийн барилгын сантехникийн засвар 32,968.4 мянга, 2020.06.30-ны өдрийн 04-р тогтоолоор 8 төрлийн тоног төхөөрөмжийг 15,680.0 мянга, 2020.12.28-ны өдрийн 80-р тогтоолоор үндсэн хөрөнгө ашиглалтын хугацаа сунгах үнийг шинэчлэн тогтоох тогтоолын дагуу 27 нэр төрлийн 26,926.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн, мөн БСШУЯ-ны санхүүжилтээр фургон автомашин 33,600.0 мянган төгрөгөөр, нийт 109,174.4 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2020.12.28-ны өдрийн 83-р тогтоолоор 17 нэр төрлийн 23,564.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг акталж 2,478,493.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө болон өр төлбөрийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 436,497.2 мянган төгрөг болж 6,235.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 122,266.8 мянган төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй 98,012.3 мянган төгрөгийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого 19,460.1 мянга болон урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7,905.0 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Энэ нь орон тоо дутуу дутуу ажилласнаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, ковид-19 тэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой, хангамж бараа материалын, эд хогшил урсгал засварын зардлуудыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 668,702.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 668,702.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Энэ нь ажилчдын цалингийн нэмэгдэл болон тус байгууллагад шаардлагатай орон тоонд гүйцэтгэх 8, үйлчлэх 3 орон тоог нэмж тусгасан, мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эд хогшлын урсгал зардлыг тус тус нэмэгдүүлж санал хүргүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 289,996.0 мянган төгрөгөөр бууруулж буюу өмнөх онуудын дунджийг үндэслэн 378,706.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71701 буюу “Биеийн тамир спорт” хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 378,706.3 мянган төгрөгийн төсөв батласнаас

356,706.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 356,706.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөт орлого 18,471.0 мянга, нийт 375,177.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 360,533.1 мянган төгрөгийг зарцуулж, 14,644.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360,533.1 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлаас 6,170.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 1,032.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 9,870.1 мянга, хангамж бараа материалын зардлаас 83.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 10.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 974.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 20.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 1.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

### Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд заасанаар 2020 онд 22,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 18,529.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, банкны шимтгэлд 58.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор орлогын төлөвлөгөө 16.1 хувиар дутуу биелсэн байна.

*Хүснэгт 2* Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Спорт зал, усан спорт сургалтын төв, фитнес танхим | 22,000.0 | 18,471.0 | (3,529.0) | 83.9 |
| **Нийт** | **22,000.0** | **18,471.0** | **(3,462.0)** | **83.9** |

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн өсвөрийн шигшээ баг болон спортын үйл ажиллагаатай холбоотой биеийн тамир спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрөөс 41,798.0 мянга, Улсын биеийн тамир Спортын хорооны даргын 98 тоот тушаалаар цахим мэдээллийн сан бүрдүүлэх зардалд 2,000.0 мянга, мөн 2020.12.18-ны өдрийн А/97 тоот тушаалаар цахим фитнес төслийн хүрээнд зарцуулах 13,120.0 мянга, нийт 56,918.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 43,798.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаанд зарцуулж, 13,120.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 16 мэдээлэл байгаа бөгөөд анхан шатны баримттай тулган баталгаажуулахад байгууллагын хөрөнгө зарцуулахтай холбоотой 3,213.4 мянган төгрөгийн 6 тушаал шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,246.0мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 63.0 | 1 | 63.0 | | | |
| Албан шаардлага | 1 | 6,183.0 | 1 | 6,183.0 | | | |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | | | |
| Нийт дүн | 4 | 6,246.0 | 4 | 6,246.0 | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 360,368.8 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 356,897.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, шилэн данстай холбоотой зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг аудитын явцад санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд зардлыг 191.5 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан.
2. Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс санхүүжих 356,706.3 мянган төгрөгийн орлогыг тусламжийн орлогоор бүртгэсэн байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн 1 зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд А/18, А/19, А/27, Б/09, Б/20, Б/02 тоот хөрөнгө зарцуулах тушаалуудыг байршуулаагүй, 16 мэдээлэл хугацаа хоцорсон байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, ЗГ-ын 2016 оны 29-р тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5.3 дахь заалтуудыг зөрчсөн ба “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар орлогын төлөвлөгөө болон цахим төлбөрийн системтэй холбоотой илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал илэрсэнгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Цахим төлбөрийн систем, төлбөрийн баримттай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Цахим төлбөрийн системд худалдан авалтыг тулган баталгаажуулж, хяналт тавьж ажиллаагүйгээс төлбөрийн баримтыг 941.0 мянган төгрөгөөр дутуу, 1.0 мянган төгрөгөөр илүү тусгасан.

1.2. *Эрсдэл:* Худалдан авалтуудыг цахим төлбөрийн системд мэдээлэхгүй байх, татвар төлөгч нар орлогоо нуух, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх

1.3. *Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэх, Цахим татварын системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж, хяналт тавих

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

2. *Орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал*

2.1. *Илрүүлэлт:* Тайлант онд орлогын төлөвлөгөө 22,000.0 мянган төгрөгөөр батлагдсан боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 3,471.0 мянган төгрөгөөр тасарсан, төлөвлөгөөнд тодотгол хийлгүүлээгүй байна.

2.2. *Эрсдэл:* Төлөвлөсөн зардлуудаа санхүүжүүлэх боломжгүй болох

2.3. *Өгсөн зөвлөмж:* Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 14 дүгээр зүйлийн 14.3 дэх заалтыг хэрэгжүүлэх, төсвийг зохистой удирдах, хяналт тавих

*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: ***Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: | ГСА-2020/9/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Ус, цаг уур орчны шинжилгээний төв** | Мянган төгрөг | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үр дүнгийн тайланд зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан. | 191.5 | Залруулга хийх | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лүнгэрэгжанцан |
| 2 | Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд ОН-ийн төсвөөс санхүүжих орлогыг тусламжийн орлогоор бүртгэсэн. | 356,706.3 | Залруулга хийх | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лүнгэрэгжанцан |
| 3 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэрийг дутуу оруулсан. | - | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лүнгэрэгжанцан |
| 4 | Цахим татварын системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж, хяналт тавьж ажиллаагүй. Тухайлбал: Байгууллагын харилцахаас шилжүүлсэн мөнгөн дүн e-barimt-аас 4,408.6 мянган төгрөгөөр зөрүүтэй. | - | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лүнгэрэгжанцан |
| 5 | Орлогын төлөвлөгөө 3.4 сая төгрөгөөр тасарсан. | 3,471.0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лүнгэрэгжанцан |
| **ДҮН** | | **360,368.8** | | | |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 23 өдөр Дугаар 01/23 Чойр

*Зөрчил арилгах тухай*

**Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:**

1. **Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг оруулаагүй, 16 мэдээлэл хугацаа хоцроосон байна.**

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*", 4.1.3-т " *тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх*", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "*Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан*", ЗГ-ын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 "*өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах*" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.*", 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Б.Буянтогтох, нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР М.УНДАРМАА

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

08?000351

| Ажлын баримтын нэр: | *Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл* |
|---|---|
| Ажлын баримтын дугаар: | *B501* — Аудитын код: ГСА-2021/9/СТА-ТШЗ — төгрөгөөр |
| Аудитын нэр: | Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит |

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Үр дүнгийн тайлан | 1 | Үр дүнгийн тайланд зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан. | 191,500 | Залруулга хийх | Хүлээн зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лунгэрэгжанцан |
| 2 | Үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан | 1 | Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд ОН-ийн төсвөөс санхүүжих орлогыг тусламжийн орлогоор бүртгэсэн. | 356,706,300 | Залруулга хийх | | | | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лунгэрэгжанцан |
| 3 | Шилэн данс | 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэрийг дутуу оруулсан. | - | Албан шаардлага өгөх | | | | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лунгэрэгжанцан |
| 4 | Дотоод хяналт | 1 | Цахим татварын системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж, хяналт тавьж ажиллаагүй. Тухайлбал: Байгууллагын харилцахаас шилжүүлсэн мөнгөн дүн e-barimt-аас 4,408.6 мянган төгрөгөөр зөрүүтэй. | - | Зөвлөмж өгөх | | | | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лунгэрэгжанцан |
| 5 | Орлогын төлөвлөгөө | 1 | Орлогын төлөвлөгөө 3.4 сая төгрөгөөр тасарсан. | 3,471,000 | Зөвлөмж өгөх | | | | Дарга, нягтлан бодогч | Б.Буянтогтох, Б.Лунгэрэгжанцан |
| | **Нийт** | **5** | | **360,368,800** | | | | | | |

**Бэлтгэсэн:**
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо: 2021.02.15
Аудитор М.Ундармаа

**Анхан шатанд хянасан:**
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо
Аудитын менежер Г.Наранбаяр

**Хоёр дахь шатанд хянасан:**
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа — 2021.02.18

4217144454
CA0055 901904

**Танилцаж зөвшөөрсөн:**

БТСГ-ын дарга Б.Буянтогтох Огноо

Нягтлан бодогч Б.Лунгэрэгжанцан Огноо